



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 9/16

Улаанбаатар хот

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн  
томилх тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2, 34.2.5 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журмын 3.2.3 дахь заалт, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2017 оны "Журам батлах тухай" А/315 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулах, үнэлэх журмын 2.1 дэх заалт, Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 5.15 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний нисэхийн үндэсний төвийн Гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах, гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах, гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор харьяа салбар нэгжийн зарим барилга байгууламжид мэргэжлийн байгууллагатай хамтран Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар томилсугай.

2. Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах, шаардлагатай тохиолдолд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд салбар нэгжээс албан тушаалтан, ажилтныг татан оролцуулах, үнэлгээний тайланг гаргуулан танилцуулахыг ажлын хэсгийн дарга (С.Батхуяг)-д үүрэг болгосугай.



Н.БАТСАЙХАН



Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын  
2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн  
16... дугаар тушаалын хавсралт

Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх ажлын  
хэсэгт ажиллах бүрэлдэхүүний нэрсийн жагсаалт

Ажлын хэсгийн дарга:

С.Батхуяг  
(Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн  
хэлтсийн дарга)

Гишүүд:

Ч.Даваажав  
(Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн  
хэлтсийн мэргэжилтэн)

Т.Саранчимэг  
(Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газрын ахлах  
нягтлан бодогч)

Ц.Бяраазана  
(Гэрэл суулт, цахилгаан хангалтын албаны  
Цахилгаан хангалтын хэсгийн цахилгаан хангалтын  
ахлах инженер)

Ч.Чинбат  
(Аж ахуйн үйлчилгээ, дулаан, сантехникийн албаны  
Дулаан сантехник, агааржуулалтын хэсгийн ахлах  
инженер)

Г.Ууганцэрэн  
(Аж ахуйн үйлчилгээ, дулаан, сантехникийн албаны  
Аж ахуй, барилга засварын хэсгийн барилгын  
инженер)

Нарийн бичгийн дарга:

Б.Гэрэлмаа  
(Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн  
хэлтсийн мэргэжилтэн)

--- ооо ---